БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 11 өдөр Дугаар А/158 Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр "Босго үнэ шинэчлэн батлах тухай" тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн V/04 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Аялагч, амрагчдын отоглох цэгийн тохижилтыг нэмэгдүүлэхээр тус бүр 10,000,000 (арван сая) төгрөгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрхийг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр), Хутаг-Өндөр сумын Засаг дарга (П.Лхагва-Очир) нарт тус тус шилжүүлсүгэй.

2.Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж тайлагнахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр), Хутаг-Өндөр сумын Засаг дарга (П.Лхагва-Очир) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний Аялагч, амрагчдын отоглох цэгийн тохижилтыг нэмэгдүүлэх 20,000,000 (хорин сая) төгрөгөөс санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

6320220173